



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ
ГАЗАР



World Organisation
for Animal Health
Founded as OIE



МОНГОЛ улсын
УУГАН
ҮЙЛДВЭР

БИОАЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ЭМИЙН ҮЛДЦЭЭС СЭРГИЙЛЖ, БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТИЙГ БУУРУУЛАХ НЬ

Э.МӨНХБАЯР

МЗЕГ-ын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэргэжилтэн


2026.08.06

ЭМИЙН ҮЛДЭЦ, ББТ



- 2010 онд 63,2 мян/тонн
- 2020 онд 100 мян/тонн
- 2030 онд 107,5 мян/тонн болох төлөвтэй байна.
- Зохисгүй хэрэглээ, хяналт сул, бүртгэл, тайлагнал,
- Тэсвэржсэн ББ эсрэг эм ховордох, эмчилгээгүй болох:
- 2050: 1 жилд 10 сая хүн

МАЛЫН ЭМИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ




Малы эмийг зохистой хэрэглээ гэж юу вэ? Бид юуг анхаарах ёстой вэ?

- Өвчнийг зөв оношлох
- Эм, бэлдмэлийн төрлийг зөв сонгох
- Эмийг тохирсон зөв тунгаар хэрэглэх
- Эмийн хэрэглэх хугацаа, давтамжийг зөв хэрэглэх
- Эмийн биеэс гадагшлах хугацааг баримтлах
- Эмийг зөв хадгалах тээвэрлэх нөхцөл

Малын эмийг яагаад зөв, зохистой хэрэглэх шаардлагатай вэ?


- Эмийн эмчилгээний үр дүнг хадгалж үлдэх,
- Эмэнд тэсвэртэй бичил биетэнг үүсгэхгүй байх,
- Эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх,
- Хүн, мал, байгаль орчинд эрсдэл бий болгохгүйн тулд.

ЭМ, ЭМИЙН БОДИСЫН ҮЛДЭЦ



- **Эмийн үлдэц:** эмийн бэлдмэл хэрэглэсний дараа тодорхой хугацаанд бүтээгдэхүүнд хадгалагдан үлдэхийг хэлнэ.
- **Хортон шавж устгагч, пестицид бодисын үлдэц:** үр тариа, төмс, хүнсний ногоонд хэрэглэсний дараа тодорхой хугацаанд хадгалагдах
- **Яагаад эмийн үлдэц үүсдэг вэ?** Эмийг хэтрүүлэн хэрэглэх, малын биеэс гадагшлах хугацааг мөрдөхгүй байх, эмийн буруу сонголт зэрэг.
- **Эмийн бодисын үлдэцтэй хүнсний бүтээгдэхүүн нь ямар хортой вэ?** хүний эрүүл мэндэд олон сөрөг нөлөөтэй болон бичил биетний тэсвэржилт үүсгэнэ.


БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТ



- **Бичил биетэн гэдэг нь:** өвчин үүсгэгч нян, вирус, шимэгч хорхой, мөөгөнцөр
- **Бичил биетний эсрэг эм:** нь бичил биетнийг устгадаг эсхүл үржлийг нь саатуулдаг эм, бэлдмэл, бодис
- **Бичил биетний тэсвэржилт:** гэдэг нь өвчин үүсгэгч нян, вирус, шимэгч хорхой, мөөгөнцөр зэрэг бичил биетэн эм, бэлдмэлд эмчилгээ, үйлчилгээ үр дүнгүй болохыг хэлнэ.
- **Тэсвэржсэн бичил биетэн тархах зам:**
 - Малын гаралтай хүнсний бүтээгдэхүүн
 - Бохирдсон хөрс, ус, ургамал
 - Мал, амьтны ялгадас
 - Бохирдсон орчин



АНТИБИОТИКТ ТЭСВЭРТЭЙ БОЛСОН БАКТЕРИ ТЭСВЭРЖИЛТИЙН ШИНЖИЙГ БУСАД БАКТЕРИД ХЭРХЭН ДАМЖУУЛДАГ ВЭ?




Зарим бактери
антибиотикт
тэсвэртэй болно.

Тэсвэртэй болсон
бактери
антибиотикийн
эмчилгээнд
үхэхгүй үлдэнэ.

Тэсвэртэй бактери
цааш үржиж
олширно.

Тэсвэртэй болсон
бактери
тэсвэржилтийн
мэдээллийг бусад
бактерид дамжуулна.

МАЛЧИД, ФЕРМЕРҮҮД БИД ББТ-ТЭЙ ТЭМЦЭХЭД ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?



Малчин та ББЭЭ-ийн үр дүнг хэвээр хадгалахад чухал хувь нэмэр оруулж чадна.

Эрүүл малтай айл өрх

- Малын өвчнөөс урьдчилан сэргийлэх
- Хяналтыг нэмэгдүүлэх
- Малын шилжилт хөдөлгөөнд болгоомжтой хандах
- Биоаюулгүй байдалд анхаарах
- Өвчний эрсдэлтэй байж болзошгүй мал сүргийг яаралтай тусгаарлах

Малд эмчилгээ хийх тохиолдолд

- Малын эмчид үзүүлэх
- Бичил биетний эсрэг эм хэрэглэхээс өмнө оруулах эмчилгээг сонгох
- Антибиотик зэрэг ББЭЭ-ийг хэрэглэх тохиолдолд жорын дагуу авч хэрэглэх
- Мал, амьтанд эмийг малын эмчийн зааврын дагуу (тун, хугацаа, давтамж, биеэс гадагшлах хугацаа)

Малчид, фермерүүд бид ББТ-тэй тэмцэхэд юу хийж чадах вэ?

Мал аж ахуйн сайн дадал болон урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг хэрэгжүүлснээр зарим малчид болон фермерүүд бичил биетний эсрэг эмийн хэрэглээг мэдэгдэхүйц бууруулж, үйлдвэрлэлийн бүтээмжээ нэмэгдүүлэхийн зэрэгцээ амьжиргаагаа дээшлүүлж, орон нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж байна.

Хэрэгжүүлэхэд хялбар энгийн дадлууд:



УГААХ
Гар болон
саалтуур



ӨМСӨХ
Зориулалтын
хамгаалалтын
хувцас, гутал



**ЦЭВЭРЛЭЖ,
ХАЛДВАРГУЙ-
ЖҮҮЛЭХ**
Малын байр, тоног
төхөөрөмж болон
тээврийн хэрэгсэл

Малчдын хийж болох энгийн арга ХЭМЖЭЭ:

- Малын байр, хашаа, тоног төхөөрөмжийг тогтмол цэвэрлэх
- Ус, тэжээлийн чанар, хүртээмжийг сайжруулах
- Малын эрүүл мэнд, биеийн байдлыг өдөр бүр ажиглах
- Шинээр авсан болон өвчний сэжигтэй малыг бусад малаас тусгаарлах
- Малын эмчийн зөвлөгөөний дагуу вакцинжуулах
- Хашаа, байр, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн ариутгал хийх
- Мал аж ахуйн биоаюулгүй байдлын дэглэмийг мөрдөх

ЭМИЙН ҮЛДЭЦ, БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТТЭЙ ТЭМЦЭХЭД ЧИГЛЭГДСЭН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

2017

NAP-1 /2017-2020/



Эмийн
үлдэгдлийн
хяналтын
хөтөлбөр

2022

NAP-2 /2022-2025



Хүнсний хангамж,
аюулгүй байдал
УИХ-ын 36-р тогтоол

2024



Мал, амьтны
эмийг
жороор олгох
журам.

2025

Нянгийн
тэсвэржилтээс
сэргийлэх салбар
дундын үйл
ажиллагааны
төлөвлөгөө
(NAP-I).

2019-2023




Бичил биетний
тэсвэржилтээс
сэргийлэх салбар
дундын үйл
ажиллагааны
төлөвлөгөө
(NAP-II)

2022-2026



Мал, амьтны эм,
тэжээлийн
нэмэлтийн тухай
хууль

БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТИЙГ ИЛРҮҮЛЭХ ТАНДАЛТ



2023 онд бичил ББТ-ийг тодорхойлох антибиотикийн мэдрэг чанар /диск диффуз/-ын шинжилгээний арга зүйн сургалтыг 21 аймгийн мал эмнэлгийн лабораторид зохион байгуулсан.



2022 оноос эхлэн АСТ төслийн дэмжлэгтэй ББТ-ийн тандалтыг зохион байгуулсан.
2025 оноос Улсын төсвийн хөрөнгөөр УМЭАЦТЛ ББТ-ийн тандалтыг зохион байгуулж байна.



Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторуудыг ББТ-ийг тодорхойлох оношлуур хэрэглэгдэхүүнээр хангасан.



УМЭАЦТЛ нь Ази номхон далайн бүсийн ББТ-ийн лавлагаа лабораторийн ур чадварын сорилд 2023, 2024 онуудад хамрагдсан.



Антибиотикийн мэдрэг чанарын шинжилгээний (Disk diffusion method, CLSI) аргын САЗ боловсруулан баталж салбарын хэмжээнд мөрдөж байна.

АНТИБИОТИК (ПЕНИЦИЛЛИН)-ИЙН НЭЭЛТ БА ХӨГЖЛИЙН ТҮҮХ



- **1928 онд** пенициллинийг анх нээсэн.
- **1929 онд** судалгааны үр дүнг нийтэлсэн.
- **1939 онд** пенициллиний судалгаа дахин идэвхэжсэн.
- **1940 онд** амьтанд үр нөлөөг туршсан.
- **1941 онд** хүний эмчилгээнд туршиж эхлэв.
- **1943–1944 онд** үйлдвэрийн аргаар их хэмжээгээр үйлдвэрлэв
- **1945 онд** Нобелийн шагнал хүртэв.
- **1940 оны** дунд үеэс тэсвэржилт эхэлсэн.

МАЛ АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧИН



МАЛЧДАД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ

ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЬЕ!

Шүлхий өвчин гэж юу вэ?

Шүлхий нь вирусийн гаралтай мал, амьтны гоц халдварт өвчин бөгөөд салаа туурайтан амьтад өвчилнө.




Хэрхэн халдварладаг вэ?



Шүлхийн халдвар авсан, өвчилсөн мал, амьтад болон тэдгээрийн нүс, шүлс, баас, шээсээр бохирлогдсон бэлчээр, ус, малын тоног хэрэгсэл, усны онгоц зэргээр дамжина.

Халдвартай малтай харьцаж ажилласан хүний бохирлогдсон хувцас, хэрэгслээр халдвар дамжина.


Халдварласан малд ямар шинж тэмдэг илрэх вэ?



Бог малд шүлхийн шинж тэмдэг бүдэг илэрдэг тул маш хянуур хандах хэрэгтэй. Доголох шинж тэмдэг голчлон илрэх ба хэрэв үүнийг анзаарахгүй өнгөрвөл шүлхийн халдвар цааш тархах гол нөхцөл болдог.



Шүлхий өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?



Шинээр мал худалдан авсан тохиолдолд заавал 5-7 хоног тусгаарлаад эрүүл гэдгийг баталгаажуулсны дараа сүрэгтээ нийлүүлэх.


Малын эмч болон малчин та өвчтэй малтай харьцаж ажилласны дараа, халдвар хамгааллын дэглэмийг сайтар сахих ба дараах алхамуудыг мөрдөх. Үүнд:

- Гараа заавал угаах;
- Бохирлогдсон хувцсыг солих;
- Гутлын ул, хувцсыг халдваргүйтгэх, ингэхдээ нимбэгний хүчлийн 0.2-2%-ийн уусмал ашиглах;
- Бусад хот айлд халдвар тараах эрсдэлийг үүсгэхгүй байх;



Малын эмчдээ яаралтай мэдэгдэж дуудлага өгөх.

Эмчилгээ: Шүлхийн сонгомол эмчилгээ байхгүй боловч өвчилсөн малын амны хөндий, хөлийн салаа орчмыг хужир, эсвэл содын уусмал, нимбэгний хүчлийн 0.2-2%-ийн уусмалаар угаах, мөн нянгийн хоёрдогч халдвараас сэргийлэх зорилгоор антибиотикийн эмчилгээ хийж болно.



Тусгаарласан өвчтэй малд ус, өвс, тэжээл тогтмол өгөх.

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА!

